



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Эрдэнэбулган сумын хүүхдийн 3 дугаар сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2025/068/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

[www.open.audit.mn](http://www.open.audit.mn)

Архангай аймаг

2025 он

Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа

Утас: 7033-3141

Цахим хаяг: [Baigalmaat@audit.gov.mn](mailto:Baigalmaat@audit.gov.mn)

Аудитын менежер Д.Нэргүйбаатар

Утас: 7033-2860

Цахим хаяг: [Nerquibaatar@audit.gov.mn](mailto:Nerquibaatar@audit.gov.mn)

Аудитор С.Оргил

Утас: 77665858

Цахим хаяг: [Shinjlenmagadlahui.ezsh.audit@gmail.com](mailto:Shinjlenmagadlahui.ezsh.audit@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,  
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,  
Утас/Факс: (976) 7033 3141,  
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2025.02.25 № 118  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

АРХАНГАЙ АЙМГИЙН ЭРДЭНЭБУЛГАН  
СУМЫН 3 ДУГААР СУРГУУЛИЙН  
ЗАХИРАЛ Б.ЭНХБОЛД ТАНАА

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасны дагуу Архангай аймгийн Эрдэнэбулган сумын 3-р сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Аудитын гол асуудал

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх "Ерөнхий боловсрол" хөтөлбөрийн хүрээнд 13 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 3,612,162.4 мянга, орон нутгийн төсвөөс 433,790.2 мянга, урьд оны үлдэгдлээс 252,906.5 мянга, үйл ажиллагааны орлогоос 9,175.6 мянга нийт 4,308,034.7 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрдүүлж, гүйцэтгэлээр 4,045,932.3 мянган төгрөгийг зарцуулж, орон нутгийн төсөвт 6,727.0 мянган төгрөгийг төвлөрүүлэн, 255,375.3 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

#### Бусад асуудлын хэсэг

Архангай аймгийн Эрдэнэбулган сумын 3-р сургууль нь 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтуудыг хангахад чиглэсэн 8 үндсэн зорилтын 31 арга

хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд дэвшүүлсэн зорилт, арга хэмжээний хэрэгжилт 100 хувьтай байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	470,183,147.66	508,628,661.83
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	252,906,456.53	255,375,325.40
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	-	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	252,906,456.53	255,375,325.40
3121	Төгрөг	252,906,456.53	255,375,325.40
31211	Төрийн сангийн харилцах	252,906,456.53	255,375,325.40
35	БАРАА МАТЕРИАЛ	217,276,691.13	253,253,336.43
351	Түүхий эд материал	1,208,120.00	1,171,000.00
35130	Эм боох материал	1,208,120.00	1,171,000.00
354	Хангамжийн материал	216,068,571.13	252,082,336.43
35420	Аж ахуйн материал	163,955,803.03	184,173,953.03
35450	Барилгын засварын материал	23,217,723.00	29,629,873.00
35470	Бусад хангамжийн материал	28,895,045.10	38,278,510.40
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,702,520,847.43	2,984,260,096.14
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,702,520,847.43	2,984,260,096.14
392	Биет хөрөнгө	2,498,767,097.32	2,774,561,345.99
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,633,542,495.49	2,688,542,495.49
39202	Хуримтлагдсан элэгдэл	(543,766,385.72)	(656,422,492.88)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	1,910,000.00	1,910,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(1,910,000.00)	(1,910,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	386,283,075.61	540,042,538.76
39206	Хуримтлагдсан элэгдэл	(117,923,927.03)	(158,608,675.11)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	142,132,210.93	243,986,551.09
39208	Хуримтлагдсан элэгдэл	(85,439,681.24)	(84,669,542.00)
39214	Бусад үндсэн хөрөнгө	40,750,000.00	149,880,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(19,750,000.16)	(22,380,000.20)
39217	Ном	62,939,309.44	74,190,470.84
393	Биет бус хөрөнгө	203,753,750.11	209,698,750.15
39301	Програм хангамж	2,162,798.00	8,162,798.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-2,039,047.89	-2,094,047.85
39303	Бусад биет бус хөрөнгө	203,630,000.00	203,630,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,172,703,995.09	3,492,888,757.97
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,172,703,995.09	3,492,888,757.97
51	Засгийн газрын хувь оролцоо	3,172,703,995.09	3,492,888,757.97
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	-	-
51101	Өмч: - төрийн	-	-
512	Хуримтлагдсан үр дүн	721,699,397.18	1,041,884,160.06
51210	Өмнөх үеийн үр дүн	721,699,397.18	721,699,397.18
51220	Тайлант үеийн үр дүн	-	320,184,762.88
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,410,134,639.50	1,410,134,639.50
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,172,703,995.09	3,492,888,757.97

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,256,121,400.18	4,407,397,121.70
11	ТАТВАРЫН ОРЛОГО	-	-
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	137,496,100.18	361,444,521.70
120	Нийтлэг татварын бус орлого	137,496,100.18	361,444,521.70
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө		326,734,356.40
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал		25,534,565.30
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	13,542,563.00	9,175,600.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9,671,200.00	3,974,300.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,871,363.00	5,201,300.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,118,625,300.00	4,045,952,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,746,435,100.00	3,612,162,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,746,435,100.00	3,612,162,400.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,083,589,222.26	4,083,514,630.87
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,083,589,222.26	4,083,514,630.87
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,858,973,720.76	3,855,628,878.57
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,910,862,485.81	2,765,535,881.05
210101	Үндсэн цалин	1,307,124,296.81	1,732,592,710.05
210102	Нэмэгдэл	507,438,346.00	855,434,961.00
210104	Урамшуулал	96,299,843.00	177,508,210.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	240,791,485.08	346,356,942.28
210201	Тэтгэврийн даатгал	165,631,575.62	239,126,215.95
210202	Тэтгэмжийн даатгал	19,390,092.69	28,005,607.87
210203	ҮОМШӨ-ний даатгал	15,428,474.29	14,391,166.12
210204	Ажилгүйдлийн даатгал	3,667,390.86	12,965,136.09
210205	Эрүүл мэндийн даатгал	36,673,951.62	51,868,816.25
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	323,300,358.50	357,063,237.70
210301	Гэрэл, цахилгаан	12,292,625.50	21,319,827.00
210302	Түлш, халаалт	259,990,154.00	260,113,816.00
210303	Цэвэр, бохир ус	51,017,579.00	75,629,594.70
2104	Хангамж, бараа материалын зардал	18,183,995.96	3,100,000.00
210402	Тээвэр, шатахуун	-	3,100,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,681,605.00	-
210408	Бараа материал акталсны зардал	14,502,390.96	-
2105	Нормативт зардал	133,700.00	607,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	133,700.00	607,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	30,290,980.00	20,712,450.00
210604	Урсгал засвар	30,290,980.00	20,712,450.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,358,013.04	26,232,193.80
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	1,961,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,358,013.04	24,270,693.80
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	328,052,702.37	336,021,173.74
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	70,685,102.25	84,151,219.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	39,706,416.00	30,164,536.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хоргодол	217,661,184.12	221,705,418.74
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	224,615,501.50	227,885,752.30
2132	Бусад урсгал шилжүүлэг	211,125,660.00	221,158,790.00

213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	177,195,260.00	186,930,490.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	33,930,400.00	34,228,300.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	13,489,841.50	6,726,962.30
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	13,489,841.50	6,726,962.30
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>172,532,177.92</u>	<u>323,882,490.83</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	16,981,653.62	3,697,727.95
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	16,981,653.62	3,697,727.95
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(16,981,653.62)	(3,697,727.95)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>155,550,524.30</u>	<u>320,184,762.88</u>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>3,132,167,863.00</u>	<u>4,055,128,200.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	13,542,563.00	9,175,600.00
120	Нийтлэг татварын бус орлого	13,542,563.00	9,175,600.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	13,542,563.00	9,175,600.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9,671,200.00	3,974,300.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,871,363.00	5,201,300.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,118,625,300.00	4,045,952,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,746,435,100.00	3,612,162,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,746,435,100.00	3,612,162,400.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	372,190,200.00	433,790,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	372,190,200.00	433,790,200.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>2,830,808,739.93</u>	<u>3,872,251,292.13</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,830,808,739.93	3,872,251,292.13
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,606,193,238.43	3,645,289,539.83
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,910,862,484.81	2,771,921,395.31
210101	Үндсэн цалин	1,288,874,730.33	1,732,592,710.05
210102	Нэмэгдэл	525,700,046.44	872,604,580.00
210104	Урамшуулал	96,287,708.04	180,130,528.26
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	240,791,486.08	339,971,428.02
210201	Тэтгэврийн даатгал	165,788,680.29	232,180,321.90
210202	Тэтгэмжийн даатгал	19,089,708.47	27,263,587.08
210203	ҮОМШӨ-ний даатгал	15,213,206.25	13,783,597.82
210204	Ажилгүйдлийн даатгал	3,700,042.65	13,342,958.74
210205	Эрүүл мэндийн даатгал	36,999,848.42	53,400,962.48
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	323,300,358.50	357,063,237.70
210301	Гэрэл, цахилгаан	17,729,616.50	20,091,186.00
210302	Түлш, халаалт	259,990,154.00	260,113,816.00
210303	Цэвэр, бохир ус	45,580,588.00	76,858,235.70
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	35,400,000.00	15,000,000.00
210604	Урсгал засвар	35,400,000.00	15,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	24,823,213.04	39,436,812.80
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,671,200.00	4,884,100.00

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	15,152,013.04	34,552,712.80
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	71,015,696.00	121,896,666.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	46,273,456.00	91,499,976.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	24,742,240.00	30,396,690.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	224,615,501.50	226,961,752.30
2132	Бусад урсгал шилжүүлэг	211,125,660.00	220,234,790.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	177,195,260.00	186,006,490.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	33,930,400.00	34,228,300.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	13,489,841.50	6,726,962.30
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	13,489,841.50	6,726,962.30
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>301,359,123.07</u>	<u>182,876,907.87</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	92,540,460.00	180,408,039.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	92,540,460.00	180,408,039.00
2200	Дотоод эх үүсвэрээр	92,540,460.00	180,408,039.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	92,540,460.00	180,408,039.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(92,540,460.00)</u>	<u>(180,408,039.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	208,818,663.07	2,468,868.87
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	44,087,793.46	252,906,456.53
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	252,906,456.53	255,375,325.40

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,040,869,958.41	1,410,134,639.50	721,699,397.18	3,172,703,995.09
2	Тайлант үеийн үр дүн	-	-	320,184,762.88	320,184,762.88
3	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,040,869,958.41	1,410,134,639.50	1,041,884,160.06	3,492,888,757.97

#### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,306,232,600.00	4,045,932,368.83	260,300,231.17	93.96
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,306,232,600.00	4,045,932,368.83	260,300,231.17	93.96
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,067,301,100.00	3,825,697,578.83	241,603,521.17	94.06

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,958,985,800.00	2,771,921,395.31	(187,064,404.69)	93.68
210101	Үндсэн цалин	1,943,831,600.00	1,719,186,287.05	(224,645,312.95)	88.44
210102	Нэмэгдэл	872,254,800.00	872,604,580.00	349,780.00	100.04
210104	Урамшуулал	142,899,400.00	180,130,528.26	37,231,128.26	126.05
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	369,873,100.00	339,971,428.02	(29,901,671.98)	91.92
210201	Тэтгэврийн даатгал	251,513,800.00	232,180,321.90	(19,333,478.10)	92.31
210202	Тэтгэмжийн даатгал	29,589,800.00	27,263,587.08	(2,326,212.92)	92.14
210203	ҮОМШӨ-ний даатгал	14,794,900.00	13,783,597.82	(1,011,302.18)	93.16
210204	Ажилгүйдлийн даатгал	14,794,900.00	13,342,958.74	(1,451,941.26)	90.19
210205	Эрүүл мэндийн даатгал	59,179,700.00	53,400,962.48	(5,778,737.52)	90.24
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	363,790,200.00	357,063,237.70	6,726,962.30	98.15
210301	Гэрэл цахилгаан	21,696,000.00	20,091,186.00	1,604,814.00	92.60
210302	Түлш, халаалт	259,945,600.00	260,113,816.00	(168,216.00)	100.06
210303	Цэвэр, бохир ус	82,148,600.00	76,858,235.70	5,290,364.30	93.56
2106	Эд хогшил худалдан авах	70,000,000.00	70,000,000.00	-	100.00
210604	Урсгал засвар	70,000,000.00	70,000,000.00	-	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	86,406,600.00	74,290,187.80	(12,116,412.20)	85.98
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,365,500.00	4,884,100.00	(481,400.00)	91.03
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	81,041,100.00	69,406,087.80	(11,635,012.20)	85.64
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	218,225,900.00	212,451,330.00	(5,774,570.00)	97.35
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	186,630,500.00	180,855,930.00	(5,774,570.00)	96.91
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	31,595,400.00	31,595,400.00	-	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	238,931,500.00	220,234,790.00	(18,696,710.00)	92.17
2132	Бусад урсгал шилжүүлэг	238,931,500.00	220,234,790.00	(18,696,710.00)	92.17
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	204,703,200.00	186,006,490.00	(18,696,710.00)	90.87
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	34,228,300.00	34,228,300.00	-	100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,872,442,400.00	3,621,338,000.00	(251,104,400.00)	93.52
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,612,162,400.00	3,612,162,400.00	-	100.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	3,612,162,400.00	3,612,162,400.00	-	100.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	433,790,200.00	427,063,237.70	6,726,962.30	98.45
132001	Орон нутгийн төсвөөс	433,790,200.00	427,063,237.70	6,726,962.30	98.45

120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	260,280,000.00	9,175,600.00	(251,104,400.00)	3.53
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,365,500.00	3,974,300.00	(1,391,200.00)	74.07
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,256,500.00	5,201,300.00	944,800.00	122.20
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	250,658,000.00	00.00	(250,658,000.00)	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	252,906,456.53	252,906,456.53	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	255,375,325.40	255,375,325.40	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	-
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	101.00	106.00	5.00	104.95
620001	Удирдах ажилтан	4.00	4.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	77.00	78.00	1.00	101.30
620003	Үйлчлэх ажилтан	20.00	24.00	4.00	120.00
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	1,593.00	1,738.00	145.00	109.10
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	1,593.00	1,738.00	145.00	109.10
630001	Төрийн өмчит ЕБС	1,593.00	1,738.00	145.00	109.10

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа<sup>1</sup> илрээгүй тул залруулга хийгээгүй. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 1 зөрчил<sup>2</sup> илэрсэн бөгөөд зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлээ. Аудитаар илэрсэн зөрчил нь материаллаг бус байх тул **Өөрчлөлтгүй дүгнэлт** өглөө.

#### 3.1. Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### Илрүүлэлт:

Нягтлан бодох бүртгэлийн цахим программыг өдөр тутмын ажил гүйлгээнд ашиглаагүй, бараа материалын зарлагын гүйлгээнүүдийг нэгтгэж сарын сүүлийн өдөр программд оруулсан, анхан шатны баримтыг программаар боловсруулаагүй гар аргаар хөтөлсөн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2, 13 дугаар зүйлийн 13.1 дэх заалттай нийцэхгүй байна.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлд нярвын программыг ашиглалтыг сайжруулж бараа материалын гүйлгээг тухай бүртгэх, анхан шатны баримтыг программаар боловсруулж ажиллах зөвлөмж хүргүүлээ.

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д "... албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ" гэж заасан тул зөвлөмжийн төлөвлөгөөг 2025.03.25-ны өдрийн дотор Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт хүргүүлж ажиллана уу.

Энэхүү зөвлөмжийн төлөвлөгөөг ирүүлээгүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2 дахь хэсэгт заасан ажлаас халах сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болохыг анхааруулна уу.

*Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.*

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Няrvын программ ашиглалт, анхан шатны баримтын боловсруулалт, бараа материалын тайлантай холбоотой асуудал	1		-	-			1	-				
<b>Нийт дүн</b>	<b>1</b>						<b>1</b>	<b>-</b>				